



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/151


Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Зорилтот жил болгон зарлах тухай" 15/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2023 оныг "Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх" жил болгон зарласантай холбогдуулан сумын зорилтот жилийн нээлтийн арга хэмжээний зардалд 901,000 (есөн зуун нэгэн мянга) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.



ДАРГА

Т.БАЯРМӨНХ